

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ  
эрдэм шинжилгээний бичиг

Tom. XXXI (328)

2010

100-105

ТОД ҮСЭГ СУДЛАЛЫН АСУУДЛУУД

О.Самбуудорж<sup>1</sup>

Одоо үеийн монгол хэл, аялгууг *нэгдүгээрт*, төв монгол хэлний аялгуу, нутгийн аялгуу *хоёрдугаарт*, салангид монгол хэл, аялгуунууд гэж хоёр хэсэгт хувааж болно. Төв монгол хэл, аялгууны монголчууд нь аман харилцааны хувьд шууд харилцаж чадах боловч бичгийн хэлний хувьд энгийн хүн уншиж ойлгоход бэрхшээлтэй хэд, хэдэн бичгийн хэлтэй болсон байна. Салангид монгол хэл, аялгуунууд нь өөрийн бичгийн хэл үгүй, харьяалагдаж буй улс орныхоо бичгийн хэлийг хэрэглэж байна. Дагуур монголчууд монгол, кирилл, латин үсэгт суурилсан бичгийн хэлтэй болох туршлагыг хэд хэдэн удаа идэвхийлжээ.

Уламжлалт худам монгол бичгийн хэл нь –энэ завсар ойрд монголчууд тод монгол үсгийг 1648 онд зохион хэрэглэсэн гэсэн ч тод монгол үсэг нь худам монгол үсгийн бичгийн хэлтэй маш холбоотой нэг бичгийн хэл мэт байсан тул– тэднийг хэл аялгуу, оюуны соёлын хувьд нэгтгэхэд ихээхэн үүргийг гүйцэтгэж иржээ. Харин одоо үед төв монгол хэлний монголчууд өөр өөрийн аялгуунд суурилсан бичгийн хэл хэрэглэж буй нь тэдний хэл аялгуу, оюуны соёлд зааг ялгаа үүсэх шалтгаан болдог байна.

Үүнээс үүдэн тэдний бичгийн хэлийг ямар ч “*харилцаа хамааралгүй хэл аялгууны бичгийн хэл, ойрын төрөл монгол хэл аялгууны бичгийн хэл, нэг эх монгол хэлний нутаг нутгийн аялгууны бичгийн хэл*” гэсэн зарчмын асуудлууд үүсч байгаа болно. Иймд монгол хэлт ард түмнүүд бичгийн хэлэндээ дундын нэр томьёо тогтоох талаар илүү анхаарч чадвал тэдний соёл, угсаа гарвалын харилцаа хамааралд эерэг нөлөөтэй байж болох билээ.

Тэдэнд тогтвортой, цаг хугацаанд захирагдахгүй соёлын хэлхээ холбоо бол бичгийн хэлний соёлын холбоо юм. Гэвч монгол хэлт ард түмний олонх, бараг бүгдээрээ бусад монголчуудынхаа бичгийн хэлээр уншихгүй, бичихгүй, алба, албан бус

<sup>1</sup> Доктор. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн

харилцаанд дагаж хэрэглэхгүй учир бичгийн хэлний соёлын харилцаа холбоо нь соёлын бусад харилцаа холбооноос үлбэгэр сул дорой байдаг байна. Монгол хэлт ард түмний бичиг үсгийн дундын шинэчлэл, ялангуяа өнөө үеийн интернетийн харилцаанд аль нэг бичгийн хэлний зөв бичих дүрмийг дагасан латин үсгээр бичих дүрмийг хэрэглэж заншвал тэдний харилцаанд илүү эерэг нөлөө үзүүлэх боломж бас байж болох байна.

Түүхэн баримтыг үндэс болговол тод монгол үсгийг зохиосон он цагийн талаар маргалдах шалтгаан үе үе цухалздгийг эрдэм шинжилгээний талаар онц ач холбогдолгүй гэж болох байна. Худам монгол үсгийг засамжлан тод монгол үсгийг зохиосон шалтгааныг *“Үзгийн найрлага оршвой”* хэмээх цагаан толгой, бусад *орчуулгын зохиолын төгсгөлийн үгэнд* зохиогчийн өөрийнх нь өгүүлснээр болон *«Сарны гэрэл»* зэрэг сурвалж бичигт тэмдэглэсэн мэдээ, түүнчлэн судлаач нарын саналыг нэгтгэн үзвэл *нэгдүгээрт*, тухайн үеийн нийгэм, цаг үеийн байдлаас хамааран улс орны тусгаар тогтнолыг хамгаалах улс төрийн зорилго, *хоёрдугаарт*, бурхны шашны ном зохиолыг орчуулж нийт монгол нутаг, монгол хэлтэнд дэлгэрүүлж шашны бодлогоор тэдний эв нэгдлийг бэхжүүлэх, *гуравдугаарт*, уламжлалт худам монгол үсгээ засан сайжруулж ярианы хэлэнд ойртуулан бичиг үсэг сурах явцыг хөнгөн хялбар болгож нийтийг хурдан хугацаанд бичиг үсэгт сургах гэсэн нийлмэл цогц шалтгаануудын улмаас тод монгол үсгийг зохиожээ гэх үндэс байгаа болно.

Ийнхүү *“Омог монгол улсын хувьтанд (хувь хүн бүхэнд) хялбар болохын тул, Олон адил дүрстэй үсэг нугуудыг (үсгүүдийг), Онц тус бүр ангид хольцол үгүй гийгүүлэн ялгаж, Олхуяа (олоход, олж танихад) хялбар монгол үсэг зас хэмээн дурдагсанд”* тод монгол үсгийг зохион нийт монголчуудын дунд дэлгэрүүлэх гэсэн зорилт нь эцсийн дүндээ ойрд монголчуудын дунд дэлгэрч уламжилсан нь нийгмийн түүхэн орчин, үсэг зүйн тод болгосон дүрэмтэй холбоотойгоос гадна, худам монгол үсгийг нэгэнт сурч хэрэглэж хэвшсэн хүнд тод монгол үсгээр бичих нь сонирхолгүй, төвөгтэй мэт санагдах шалтгаануудтай холбоотой байна. Хэдий тийм ч тод монгол үсэг нь өргөн уудам нутагт тархаж, эдүгээ гэсэн ч монголчуудын оюуны соёл, хүн ардыг соён гэгээрүүлэхэд зохих үүргийг гүйцэтгэсээр байна. Тод монгол үсгийн үсэг зүй, урт эгшигийг тэмдэглэх арга, эгшиг зохицох ёс, эгшиг жийрэглэх, гээгдэх зэрэг дүрэм нь монгол хэлний хөгжлийн бодит байдлын нэгэн үеийг танин мэдэхэд ихээхэн ач холбогдолтойгоос гадна, хожим үеийн бичгийн хэлнүүдийн зөв бичих дүрэмд ч нөлөөлсөн байна.

Тод монгол үсгийн урт эгшиг тэмдэглэх аргын нэг болох уртатгалын «-» тэмдгийг зарим судлаачид тухайн эгшигийн уртыг заасан тэмдэг, зарим судлаачид биеэ даасан урт эгшиг гэж үзэх хоёр өөр санал байгаа нь дараахь шалтгаануудтай холбоотой

байна.

1-рт, «  $\text{ᠤᠯᠠᠭᠠᠨ}$  ·  $\text{ᠰᠠᠭᠠᠨ}$  ·  $\text{ᠵᠢᠷᠭᠠᠨ}$  ·  $\text{ᠳᠡᠷᠡ}$  ulān, saḡān, zurḡā, dēre (улаан, цагаан, зургаа, дээр) » гэсэн жишээг үзвэл хэлбэр болоод үүргийн хувьд тухайн эгшгийг уртаар дуудахыг зааж тэмдэглэсэн тэмдэг гэж үзэх үндэс байна.

2-рт, Монгол бичгийн уламжлалт бичлэг, одоо үед зарим талаар ойрд аялгуунд эгшгийг хэлээр зохицуулах ёсон «  $\text{ᠲᠤ}$  ·  $\text{ᠲᠤᠭᠤᠨ}$  ·  $\text{ᠪᠣᠭᠤᠨ}$  ·  $\text{ᠪᠡᠷᠡᠨ}$  tō/toā, zoḡōl/zoḡoāl, ködō/ködōē, bōgō/bōgōē (тоо, зохиол, хөдөө, бөөр) » гэсэн жишээг ажиглавал тухайн эгшгийг уртаар дуудахыг заасан тэмдэг, тухайн богони эгшгийн дараа урт «ā, ē» эгшгийг нэмж бичсэн тэмдэг гэсэн хоёр зүйл ажиглагдаж байна.

3-рт, Тод монгол үсэгт «  $\text{ᠪᠠᠷᠢᠳ}$  ·  $\text{ᠪᠢᠴᠢᠳ}$  » гэж бичсэнийг ойрдын нутгийн аль ч аман аялгуунд « bariḡ, biḡiḡ » гэж уншихгүй, « bariād, biḡiēd (бариад, бичээд) » гэж унших учир « i » эгшгийн дараа урт «ā, ē» эгшгийг нэмж бичсэн гэх байдал бас ажиглагдаж байна.

Тод монгол үсгийн урт эгшгийг тэмдэглэдэг ийм арга нь судлаачдыг өөр өөр санал гаргах шалтгаан болдог байна. Гэвч тод монгол үсэгт урт эгшиг тэмдэглэх ийм арга нь анх тухайн эгшгийн уртыг тэмдэглэх үүрэгтэй байсан гэж болно. Харин яваандаа унших, бичих хэрэгцээ, хэмнэлээс шалтгаалаан эгшгийн уртыг заасан уртатгалын «-» тэмдэг нь урт «ā, ē» эгшгийг ч давхар орлуулж бичих үүрэгтэй болсон байна. Тухайлбал, богино «i» эгшгийн дараа урт «ā, ē» эгшгийг бичихдээ шууд уртатгалын «-» тэмдэг тавьдаг нь тухайн «i» эгшгийн дараа «a, e» эгшгийг бичээд түүний ард уртатгалын тэмдэг тавивал үсгийн зурлага, бичлэг таарахгүй байсан учир үсэг зүйн хэмнэлээр урт «a, e» эгшгийг зөвхөн түүний уртатгалын тэмдгээр орлуулсан байна. Ийм байдал нь богино «i» эгшгээр төгссөн үгэнд урт «uḡ, üü» эгшгийг бичихдээ түүний нэгийг хасаж бичиж байгаа нь өмнөх жишээг гэрчлэх төдийгүй, бас үсэг зүйн хэмнэлтэй холбоотой байна.

Тод монгол үсгийн бичгийн хэлээс тухайн болон одоо үеийн монгол хэл аялгууны хэлзүйн хувьсал хөгжлийг танин мэдэх олон жишээ баримтыг мөн ажиглаж болно. Тухайлбал, тод монгол үсгийн уламжлалт бичгийн хэлэнд нэр үгийн олны утга илэрхийлэх «-nar(-ner), -noḡoud» дагавар, хааяа цөөн үгэнд «-s, -d» тохиолддог бол, одоо үед «-noḡoud» дагаврын оронд «-muud(-müüd)» дагавар, бас заримдаа «-uud

(-üüd)», «-čüüd(-čüüd)» дагавар хэрэглэж байгаа нь бичгийн хэл болон нутгийн аялгууны холбоо, мөн монгол хэл, аялгууны хувьсал хөгжлийн чиг хандлагыг харуулсан жишээ юм. Тод монгол үсгийн бичгийн хэлэнд хэлзүйн дагавар, нөхцөлийг эгшиг зохицуулан « $\dot{\text{š}}\text{atā}$ ,  $\text{bütē}$ ,  $\text{zoqsō}$ ,  $\text{ōnjō}$  (шатаа, бүтээ, зогсоо, өнжөө)» гэж мэтээр бичиж буй нь монгол хэл, аялгууны бичгийн хэл болон эгшиг зохицох ёсны улирал, хувьслыг харьцуулан судлахад чухал хэрэглэгдэхүүн болно.

Тод үсгийн бичгийн хэлэнд монгол улсын кирилл үсгийн бичгийн хэлний бүр үйлдэх байдлын «-чих(-ч)» хэлбэр тохиолдохгүй байна. Тод үсгийн бичгийн хэлэнд энэ үүргийг «-ж(-ч) + орхих» гэсэн задлаг хэлбэр гүйцэтгэж байгаа нь кирилл үсгийн бичгийн хэлний тухайн «-чих(-ч)» бүтээврийг хэлэхийн явцад «-ж(-ч) + орхих» хэлбэр хураагдсанаас үүссэн гэх баримтыг нотлоход тус болох жишээ юм. Харин орчин цагийн монгол хэлний «-аадах, (-ээдэх, -оодох, -өөдөх)» хэлбэрийг «-аад(-ээд, -оод, -өөд) + өг, эсвэл орхи» гэсэн үгтэй хоршсоноос үүсч буй ярианы хэлний хэлбэр гэж болно.

Тод монгол үсгийн бичгийн хэлний үгийн сангийн бүрэлдэхүүн, түүний бичлэгийн зарим онцлог нь мөн тухайн үеийн болон одоо үеийн монгол хэл, аялгууны үгийн сангийн хувьсал, хөгжлийн байдлыг танин мэдэхэд чухал хэрэглэгдэхүүн болж байна. Жишээ нь, тод монгол үсгийн одоо үеийн дурсгалд « $\text{a}_{\text{тг}} \text{bide}$  (бид)» гэж бичиж буй төлөөний үгийг түрүү үеийн бичгийн дурсгалд « $\text{a}_{\text{тг}} \text{bida}$  (бид)» гэж бичиж байна. Энэ нь тухайн төлөөний үг «бид» нь олон тооны «-d» дагавар залгасан хэлбэрээс бус « $\text{bi} + \text{ta}$  (би + та)» гэсэн төлөөний үгүүдийн нийлбэрээс үүссэн гэж үздэг зарим судлаачдын сонирхлыг татах жишээ юм. Баримт жишээг үзвэл тод монгол үсгийн бичгийн хэлний үгийн сангийн бүрэлдэхүүн нь зарим үгийн авианы хувьсал, ойролцоо утгатай үгийг сольж хэрэглэх тохиолдол, нутгийн аялгууны онцлогтой үгийг эс тооцвол үндсэндээ худам монгол болон монгол улсын кирилл үсгийн бичгийн хэлний үгийн сангийн бүрэлдэхүүнтэй адил гэж болох байна.

Үүнээс үзвэл тод монгол үсгийн бичгийн хэл нь хэдий өөрийн өвөрмөц онцлогтой ч ялангуяа худам монгол бичгийн хэлтэй нягт холбоо бүхий монголчуудын утга зохиолын хэлний уламжлал, ардын аман зохиолын баялаг өв суурин дээр үүсэн бүрэлдсэн, нийт монголчуудын утга зохиолын хэлний их сав гольдролд багтах, түүний нэг салбар мөчир болох утга зохиолын хэл буюу бичгийн хэл гэж болох ажээ.

Тод монгол үсгийн бичгийн хэл нь эцсийн дүндээ монгол туургат ард түмний утга зохиолын хэлийг урагш ахиулан хөгжүүлэх, урлаг, утга зохиол, соёлыг түгээн

дэлгэрүүлэх, хүн ардыг соён гэгээрүүлэхэд их хувь нэмрийг оруулж ирсэн байна. Эдүүтээ шинжааны монголчуудыг тод монгол үсгээс худам монгол үсэгт шилжүүлэхээр тогтсон явц эцсийн дүнд биеллээ гэж үзвэл тод монгол үсгээр бичиж туурвисан соёлын дурсгалуудын болон монгол хэл аялгууны хувьсал хөгжлийг танин мэдэх, судлах хэрэглэгдэхүүний үнэ цэн хойшид ч хадгалагдсаар байх нь тодорхой юм.

### АШИГЛАСАН ЭХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

1. Г. Жамьяан, Тод үсгийн зөв бичих дүрэмд урт эгшгийг хэрхэн тэмдэглэсэн тухай асуудалд. - « Монголын судлал », Уб., 1969, Т. VII, х. 257-269.
2. Г. Жамьяан, Обозначение долгих гласных в ойратском "Ясном письме", (Перевод с монг. Г.Д.Санжеева), - « Народы Азии и Африки », Москва., 1970, №5, с. 151-153.
3. Х. Лувсанбалдан, Тод үсэг, түүний дурсгалууд. УБ., 1975, 156 тал.
4. Ш. Лувсанвандан, Ойрдын тод үсгийн дурсгалын зүйлийг галиглах тухай асуудалд. - « Монголын судлал » Том. III (II), Fasc. 3, Ulan-Bator 1975, х. 38-48 тал.
5. Я. Лүнтүү, Ойрд нутгийн аялгуу хийгээд тод үсэг. Шинжааны Ардын Хэвлэлийн Хороо. 2003, 426 тал.
6. Ц. Д. Номинханов, Очерк истории кальмыцкой письменности. М., 1976, 140 с.
7. Ш. Норов, Заяа бандида. -Хөх хот., 1990.
8. Д. А. Павлов, Зая пандита создатель старокалмыцкого литературного языка. В.кн.: - « 320 лет старокалмыцкой письменности », Элиста., 1970 срт. 41-49.
9. Раднабадра (Radnabhadra), Rab 'byam za ya bandida-in touji sarayin gerel kemeki. -Хэл зохиолын хүрээлэнгийн номын сан. Данс 691(26)
10. Б. Ринчен, Ойратские переводы с китайского. - « Zakiad orientalistyki Polskiej Akademii Nauk, Rocznik orientalistyczny » XXX, I, Warszawa, 1966.
11. Б. Ринчен, Тод монгол бичиг, түүний соёлын ач холбогдол. - « Монголын судлал », Том. VIII, Fasc 22, Уб., 1971. х. 293-294.
12. О. Самбуудорж, Тод монгол үсэг. - « Төв Азийн нүүдэлчдийн бичиг үсгийн товчоон », I. Уб, 2001. х. 213-234
13. Очирбат Самбуудорж, Масару Хашимото., Тод монгол үсгийн бичгийн хэлний тойм. (Монгол хэлээр) Осака., 2005. VIII+241 тал
14. О. Самбуудорж, Тод үсгийн болон ойрд аялгууны урт эгшгийн онцлог. - « Тод үсэг 360 » Ховд., 2008, х. 70-78
15. Ц. Шагдарсүрэн, Монгол үсэг зүй, Тэргүүн дэвтэр. Уб., 1981, 168 тал.
16. Ц. Шагдарсүрэн, Монголчуудын бичиг үсэг. - « Монгол судлалын эрдэм

шинжилгээний бичиг », Уб., 2001, х. 28-75.

17. Н. С. Яхонтова, Ойратский литературный язык XVII века. Москва., 1996, 152 с.

## SUMMARY

In the first part of the article the author states about written language of Modern Mongolian language community and origin of it. For Mongolian language community, cultural relationship that is not ruled by time is written language relationship. Especially at present time it is important to have written language with common orthography for internet communication.

In the second part the author stated his view about the reason of Clear script origin, its cultural significance and orthography. He assumed that when /a, e/ was written after /i/ vowel trait was not appropriate, so that /-/ symbol of length crossly stands for /a, e/. For example: barīd (bariad), bičīd (bicied) etc.

Formerly symbol of length /-/ had role for marking for long vowels, but today it marks for long vowel and as well as for /a, e/ vowels depending on writing and reading demand and economy.